



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар A/168

Мандалговь

Г
Архи, согтууруулах ундаа худалдах
түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрх
олгох, сунгах тухай

Монгол Улсын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй Мөнхдэлгэрэх-Оюу, Цант-Өлзийт, Сэргүн Онги, Тойн хайрхан, Хос гарьд магнаг, Төгрөгийн итгэлцэл, ХХК-ны хүнсний дэлгүүрүүдийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хугацаагаар тус тус сунгасугай.

Хоёр. Сайнцагаан сумын Жинд болор ХХК-ны Болор плаза худалдааны төв, Өндөршил сумын Шилийн хурд ХХК-ны хүнсний дэлгүүрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хугацаагаар олгосугай.

Гурав. Мөнхдэлгэрэх-Оюу, Тойн хайрхан, Хос гарьд магнаг ХХК-ны хүнсний дэлгүүр, Жинд болор ХХК-ны Болор плаза худалдааны төвийн ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 08.00-24.00, Шилийн хурд, Цант-Өлзийт, Сэргүн Онги, Төгрөгийн итгэлцэл ХХК-ны худалдааны газруудын ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 09.00-21.00 цаг хүртэл хугацаагаар тус тус баталсугай.

Дөрөв. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О. БАТ-ЭРДЭНЭ

482010467